



2018 оны 12 сарын 03ны өдөр

А/35

Түнхэл

**Золбин нохой устгах  
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.21-т, Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 дах заалт, сумын Засаг даргын 2017 оны 386 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Тосгоны хэмжээнд золбин нохойн тоо элбэгшиж, хүн, мал амьтдыг зуух, гэмтээх, амгалан тайван байдал алдагдуулах, халдварт өвчин тараах зэрэг сөрөг нөлөө үзүүлж байгааг таслан зогсоох ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Мөнхтүвшин – БОХ-н Улсын байцаагч

Гишүүд: Н.Цэцэгжаргал – НД-н байцаагч

а/ч Б.Батгэрэл –Хэсгийн цагдаа

А.Күнболат – Захирагчийн албаны жолооч

Б.Мөнхбаатар – Захирагчийн албаны жижүүр

Ч.Баасанхүү-Захирагчийн албаны жижүүр

С.Жүнсбек- Захирагчийн албаны жижүүр

2.Тосгонд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудыг золбин нохой устгах ажилд оролцох хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

3.1.Золбин нохой устгах ажлыг тосгоны хэмжээнд 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2018 оны 12-р сарын 20-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

3.2.Золбин нохой устгах ажлыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг өндөр түвшинд сахин ажиллах.

3.3.Нохой устгах үеийн аюулгүй байдлыг хангах.

3.4.Ажил үүргийн хуваарь гарган ажиллах

4.Галт зэвсэгтэй харьцах үеийн аюулгүй байдлын ажиллагааг хангуулан, заавар зөвлөгөөгөөр хангах, хяналт тавьж ажиллахыг тосгоны цагдаа а/ч /Б.Батгэрэл /-д даалгасугай.

5.Заагдсан хугацаанд ажлыг гүйцэтгэн Засаг даргад тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч /Ч.Мөнхтүвшин/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.ОЮУНГЭРЭЛ